

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨГРӨГ СУМАНД ХАМААРАЛТАЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Өвөрхангай аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй сумын бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө сумын бодлогын баримт бичгүүдэд хэрхэн тусгагдсаны харьцуулан үзвэл:

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүний хөгжил : “Үндэсний бахархал, соёлын өв” 1 зорилтын 4 арга хэмжээ, Эрүүл мэнд 2 зорилтын 3 арга хэмжээ, биеийн тамир 1 зорилтын 2 арга хэмжээ, боловсролын 6 зорилтын 17 арга хэмжээ хүүхэд залуучууд гэр бүлийн хөгжил 2 зорилтын 4 арга хэмжээ, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын 4 зорилтын 12 арга хэмжээний хэрэгжилтийн хангуулан ажиллаж байна. Энэ салбарын 42 арга хэмжээнээс 39 арга хэмжээ хэрэгжүүлсний "үр дүнтэй"-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувь – 23, . "тодорхой үр дүнд хүрсэн"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 90 хувьтай – 14, 70 хувьтай - 2 байх ба салбарын нийт дундаж нь 96,5 %-тай хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангах, Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэх 4 зорилт 9 арга хэмжээ бүгд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдан хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлэх 1 зорилт 5 арга хэмжээнээ тусгагдаж 100 хувь хэрэгжиж байгаа – 1, 90 хувьтай – 3, 70 хувьтай -1, Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар орон нутагтаа тав тухтай ажиллах амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх 2 зорилтын 5 арга хэмжээ тусгагдаж хэрэгжилтийн 100 хувьтай -2, 90 хувьтай – 1, 70 хувьтай – 2 байх ба салбарын нийт дундаж 91,3 хувийн хэрэгжилттэй байна.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнөөс Ес зүй, хариуцлагатай төрийн алба 2 зорилтын 5 арга хэмжээ, эрх зүйн боловсролтой иргэн хүний эрхийг хамгаалах нийгэм зорилтын 1 арга хэмжээ- 2 арга хэмжээ, Авлигагүй засаглал 1 арга хэмжээ-1 арга хэмжээ, хүний эрх, нийгмийн амар тайван байдал 1 арга хэмжээ-1 арга хэмжээ, батлан хамгаалах зорилтын 2 арга хэмжээнээс 3 арга хэмжээ зэрэг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаж биелэлтийг хангуулан ажиллаа. Засаглалын бодлого нийт 12 арга хэмжээ тусгуулан ажилласнаас "үр дүнтэй"-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага

зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувь - 2, тодорхой үр дүнд хүрсэн"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 90 хувьтай – 9, 70 хувьтай – 1 байх ба салбарын нийт дундаж нь 91,6 %-тай хэрэгжүүлэн ажиллаж байна.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧИН

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд ногоон хөгжил, байгаль орчны ерөнхий зорилгыг “хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, байгалийн баялгийг зүй зохистой ашиглан, нөхөн сэргээж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх” гэснийг сумын хэмжээнд бодлогын баримт бичигтээ тусган ажиллаж байгаа. Ногоон хөгжил, байгаль орчин салбарын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Үүнд 100 хувьтай хэрэгжсэн - 2 , тодорхой үр дүнд хүрсэн"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 90 хувьтай- 5 хэмжээ байна. Ногоон хөгжил, байгаль орчин салбарын дундаж 93,3 %-тай байна.

ТАВ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛ”ИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Аймгийн жилийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд Цар тахлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах зорилт тавин 3 арга хэмжээ хэрэгжүүлэхээр заасныг сумын түвшинд бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 салбарын 83 арга хэмжээнээс 80 арга хэмжээг сумын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан биелэлтийг гарган хэрэгжилтэд дүгнэлт хийлээ. 2022 оны хувьд 5 салбарын нийт дундаж 93,8 хувьтай байна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР